

БАТЛАВ.
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД

Х.НЯМБААТАР



ЗОХИОГЧИЙН ЭРХ БОЛОН ТҮҮНД ХАМААРАХ ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл, шаардлага

Монгол Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 140-д “Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийг шинэчлэн найруулах” гэж заасан.

Монгол Улсын оюуны өмчийн олон улсын тогтолцоонд нэгдэн орох явц тасралтгүй үргэлжилж 2015 онд “Хараагүй, харааны бэрхшээлтэй болон хэвлэмэл бүтээл унших хязгаарлагдмал чадвартай хүмүүст зориулан хэвлэн нийтлэгдсэн бүтээлийг хүртээмжтэй болгохыг хөнгөвчлөх тухай Марракешийн гэрээ”¹-нд нэгдэн орсон. Тус гэрээгээр хүлээсэн үүргийнхээ дагуу Монгол Улс хэвлэн нийтлэгдсэн бүтээлийг хараагүй болон харааны бэрхшээлтэй хүмүүст зориулан тэдний хүртэж болох хэлбэрт шилжүүлэх, ийм бүтээлийг хараагүй болон харааны бэрхшээлтэй хүмүүст зориулан үйлчилгээ үзүүлэх байгууллагаас хилээр нэвтрүүлэх, хуулбарлах, нийтэд түгээхэд зохиогчийн эрхийг хязгаарлах, чөлөөлөхтэй холбоотой зохицуулалтыг үндэсний хууль тогтоомжоор бий болгох шаардлагатай байна.

Түүнчлэн 2019 оны 12 дугаар сарын 12-ны өдөр Өргөн нэвтрүүлгийн тухай хууль, 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр Оюуны өмчийн тухай хууль батлагдсан бөгөөд Оюуны өмчийн тухай хуулийг 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөхөөр заасан. Хуулиуд хооронд зөрчил, хийдэл, давхардал үүсгэхгүй байх үүднээс Оюуны өмчийн тухай хуулийн үзэл баримтлал, зохицуулалтад нийцүүлэн Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуульд зарим шинэчлэлийг тусгах шаардлагатай юм.

1.2.Практик үндэслэл, шаардлага

Зохиогчийн эрхийн салбарт гарч буй өөрчлөлт шинэчлэлт нь технологийн хөгжил дэвшилтэй шууд хамааралтай байдаг. Тухайлбал, технологи хөгжихийн хэрээр бүтээлийн төрөл улам олширч, шинэ нэр томьёо, ойлголтууд бий болж, нөгөө талаас зохиогчийн эрхийг зөрчих, бүтээлийг илүү хялбар аргаар хувилан олшруулж, ажиллагааг улам хялбаршуулж байдаг нь энэ хуулийн зохицуулалт цаг үеэ дагаад улам нарийн, боловсронгуй болж байх шаардлагатай болж байдаг.

¹ Монгол Улсын Их Хурлын 2015 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар “Хараагүй, харааны бэрхшээлтэй, эсхүл хэвлэмэл бүтээл унших бэрхшээлтэй хүмүүст зориулан хэвлэн нийтлэгдсэн бүтээлийг хүртээмжтэй болгох тухай Марракешийн гэрээ”-г соёрхон баталсан.

Сүүлийн жилүүдэд бусдын туурвисан оюуны бүтээлийг зохиогч, эрх эзэмшигчийн зөвшөөрөлгүй ашиглах, хуулбарлах, хууль бусаар орлого олох явдал эрс өсөн нэмэгдэж байна. Нээлтээ хийгээд удаагүй хамгийн сүүлийн үеийн кино, дуу авиа бүхий дүрст бүтээлийг хуулбарлан интернэтэд тавих, телевизээр цацах байдлаар зохиогчийн эрхийг зөрчих явдал өсөн нэмэгдэх болсон. Иймд интернэтээс гадна харилцаа холбооны бусад сүлжээнд зохиогчийн эрхийг хамгаалах, бүтээлийг зохиогчийн эрх эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр ашиглахаас урьдчилан сэргийлэх технологийн хамгаалалтын арга хэмжээний талаар тусгах шаардлагатай байна.

Монгол Улсад төдийгүй дэлхий дахинд кино урлагийн болон дуу авиа бүхий дүрст бүтээлийн зах зээл улам хөгжиж байгаа учраас эдгээр бүтээлийн эрх эзэмшихтэй холбоотой зохицуулалтыг нарийвчлан тусгах хэрэгцээ байна.

Зохиогчийн эрхэд хамаарах эрх болох уран бүтээлч, фонограм бүтээгч, өргөн нэвтрүүлгийн байгууллагын эрхийг илүү дэлгэрэнгүй болгох, компьютерийн програм, мэдээллийн сангийн зохиогчийн эрхийн асуудал, дуу авиа бүхий дүрст бүтээлийн зохиогчийн эрхийн асуудлыг нэмж тусгах шаардлагатай байна.

Дүрслэх урлагийн бүтээлтэй холбоотой зохицуулалт тодорхой бус учраас эрх эзэмшигч, зохиогчид багагүй хохирол учирч байгааг өөрчлөх шаардлага бий болсон. Жишээлбэл, дүрслэх урлагийн бүтээлийг дахин борлуулалтын үнийн дүнгээс зохиогчид тодорхой хувийг төлдөг байх зохицуулалтыг нэмж тусгах шаардлагатай байна.

Газар нутаг, цаг хугацаанаас үл хамааран зохиогчийн эрхийн бүтээлийг харилцаа холбооны сүлжээгээр ашиглах боломж, техникийн нөхцөл бий болж байгаатай холбоотойгоор бүтээл ашиглах харилцаанд оролцогчид болох зохиогч, эрх эзэмшигч, тоглогч уран бүтээлч, фонограм бүтээгч, өргөн нэвтрүүлгийн байгууллага, олон суваг дамжуулагч бүрийн эрх, үүрэгтэй холбоотой зохицуулалтыг тодорхой болгох шаардлага үүсч байна.

Технологийн дэвшлийн нөлөөгөөр номын сангууд хэвлэмэл бүтээлээс гадна бүхий л төрлийн дижитал бүтээлээр номын сангийн танхимд төдийгүй интернэтээр дамжуулж үншигчиддаа үйлчлэх болсон байна. Ялангуяа сүүлийн жилүүдэд их дээд сургуулийн сурх бичиг, сургалтын материалуудын цахим сан олноор бий болж байгаа нь дээрх хэрэгцээ шаардлагын нэг илэрхийлэл юм. Мөн хараагүй болон харааны бэрхшээлтэй иргэд хэвлэмэл брайл номоос гадна тусгай форматын номын цахим сан шинээр бий болгон танхимд болон онлайнаар ашиглаж эхэлсэн. Нөгөө талаас хуучны ховор болон ганц хувь үлдсэн номыг хадгалж хамгаалах зорилгоор, хэвлэмэл номын форматыг харааны бэрхшээлтэй хүмүүсийн хэрэгцээнд зориулан аудио формат руу хөрвүүлэх зорилгоор дижитал хэлбэрт оруулах хэрэгцээ шаардлага нь зохиогчийн эрхийн бэрхшээл, маргааныг дагуулсаар байна. Иймээс хуулийн төсөлд зохиогчийн эрхтэй холбоотой үзүүлж байгаа номын сангийн үйлчилгээ, үйл ажиллагааг үйлчилгээ тус бүрийн онцлогийг харгалзан тусгайлсан зохицуулалт хийх зайлшгүй шаардлагатай байна.

Түүнчлэн Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлангийн зөвлөмж хэсэгт хамтын удирдлагын байгууллагын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, хамтын удирдлагын

байгууллага хоорондын харилцааг тодорхойлох, уялдаа холбоог хангах, хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагын механизмыг боловсронгуй болгох, ингэхдээ хууль бус үйл ажиллагаанаас олсон орлогыг зохиогчийн эрх эзэмшигчдэд нөхөн төлүүлэх ажиллагааны хэрэгжилтийг дээшлүүлэхэд анхаарч холбогдох эрх зүйн зохицуулалтыг шинэчилсэн найруулгын төсөлд тусгах шаардлагатайг дурдсан байна.

Иймд дээр дурдсан хууль зүйн болон практик шаардлагуудыг үндэслэн зохиогчийн эрхийн хамгаалалтын олон улсын гэрээ, конвенц болон дэлхий нийтийн чиг хандлагатай нийцүүлэн зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн зохицуулалтыг боловсронгуй болгох, цахим орчин, өргөн нэвтрүүлэг, олон суваг дамжуулагч /ай пи телевиз/, дуу авиа, дуу авиа бүхий дүрст бүтээлийн эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгох, зохиогч, эрх эзэмшигчийн эрхийг төлөөлөн хэрэгжүүлэх хамтын удирдлагын байгууллагын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, зохиогчийн эрхийн зөвшөөрөл шаардагдахгүй байх онцгой нөхцөлийг тодорхой зохицуулна.

Тус хуулийг шинэчлэн найруулахдаа олон улсын жишигийг дагаж тус хуулийн нэрийг Зохиогчийн эрхийн тухай хууль болгож өөрчлөх хэдий ч хуулийн үйлчлэх хүрээг хумихгүй буюу хамаарах эрхэд холбогдох зохицуулалтуудыг хуулийн төсөлд тусгана.

Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.2-т заасныг үндэслэн хуулийн нэр томьёог сайжруулах, зарим зүйл, заалтыг хүчингүй болгох, шинээр зүйл, заалт оруулах зэргээр хуулийн нийт заалтын тавиас дээш хувьд нэмэлт, өөрчлөлт орж байгаа тул төслийг шинэчилсэн найруулгын хэлбэрээр боловсруулна.

Хуулийн төсөлд дээр дурдсан үндэслэл, шаардлагад тулгуурлан зохицуулах харилцаа, хамрах хүрээг дараахь байдлаар тусгана. Үүнд:

1.Хуулийн нэр томьёоны тодорхойлолтод бүтээл, компьютерийн програм, мэдээллийн сан, зохиогчийн эрх эзэмшигч, хамаарах эрх эзэмшигч, өргөн нэвтрүүлгийн байгууллага, олон суваг дамжуулагч, дуу авиа бүхий дүрст бүтээлийн продюсер, эшлэл, нийтэд дамжуулах, нэгэн зэрэг дамжуулах, нийтэд тоглох, нийтэд дэлгэж үзүүлэх, нийтийн хүртээл болгох, түрээслүүлэх гэх мэт нэр томьёоны тодорхойлолтыг нэмэх, зарим нэр томьёог өөрчлөн найруулж тусгана.

2.Хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд шинээр компьютерийн програмын зохиогчийн эрхийн заалтыг оруулж программыг өөрөө санаачлан зохиосон, эсхүл албан үүргийн дагуу туурвисан тохиолдолд зохиогчийн эрхийг эдлэх субъектыг хуулиар тодорхойлно.

3.Дуу авиа бүхий дүрст бүтээлийг зохиогчийн эрхийн асуудлыг шинээр зохицуулна. Ингэж зохицуулахдаа дуу авиа бүхий дүрст бүтээлийн бүтээл ашиглах онцгой эрхийг хэрхэн эдлэх, дуу авиа бүхий дүрст бүтээл дэх хөгжмийн бүтээлийн зохиогчийн эрхийн асуудал, эд хөрөнгийн эрхээ продюссерт шилжүүлсэн дуу авиа бүхий дүрст бүтээлийн зохиогчийн төлбөр авах эрх зэрэг асуудлыг зохицуулна.

4.Бүтээл ашиглах онцгой эрхийн зохицуулалтад бүтээлийн эх хувийг худалдах, түрээслэх, өмчлөх эрхээ бусдад шилжүүлэх замаар нийтэд түгээх эрх, бүтээлийг

нийтэд дэлгэж үзүүлэх эрх, өргөн нэвтрүүлгийн байгууллага, харилцаа холбооны бусад сүлжээгээр нийтэд дамжуулах, нэгэн зэрэг дамжуулах, цахим сүлжээний хэрэгслийг ашиглан нийтэд түгээх зэрэг эрхийг шинээр нэмж зохицуулна. Түүнчлэн дээрх аргуудаар бүтээлийг нийтэд түгээхтэй холбоотойгоор зохиогч нь бүтээлийн ашиглалт бүрээс төлбөр авах, бүтээлийг нийтэд шууд тоглон үзүүлэх, нийтэд түгээх, өргөн нэвтрүүлгийн байгууллага болон интернэтээр дамжуулсны төлөө зохих төлбөр авах эрхийн талаарх зохицуулалтыг тусгана.

5.Гэрэл зураг болон хавсарга уран бүтээлийн хувьд зохиогчийн эрхийг хамгаалах хугацааг бүтээлийг туурвисан өдрөөс эхлэн 25 жилээр тогтооно.

6.Компьютерийн програмын зохиогч болон мэдээллийн сангийн зохиогчийн эрхийн зохицуулалтыг шинээр нэмж зохицуулна. Мэдээллийн санг үүсгэсэн этгээд эсхүл эрх эзэмшигч нь эрхээ шилжүүлсэн тохиолдолд мэдээллийн сангийн хуулбарыг түгээх эрхээ алдахаар зохицуулснаас гадна мэдээллийн санг ашиглагч этгээдийн эрх, үүргийн талаар зохицуулалтыг тусгана.

7.Хамаарах эрх эдлэх тоглогч уран бүтээлчийн эрхэд тоглолтондоо бичлэг хийх, тоглолтыг нийтэд түгээх, тоглолтын бичлэгийг түрээслэх эрхийг бичлэг үйлдвэрлэгчид шилжүүлсэн ч гэрээнд өөрөөр заагаагүй бол тоглолтын бичлэг, түүний хуулбарыг түрээсээр ашиглуулснаас зохих төлбөр авах эрх зэргийг зохицуулна. Түүнчлэн уран бүтээлчийн эд хөрөнгийн бус амины эрх болох тоглолтондоо нэрээ дурдуулах, тайзны нэр ашиглах, тоглолтыг нэр хүндэд нь хохирол учруулахуйцаар хувиргах, өөрчлөх, гажуудуулахыг хориглох эрхийг тусгана.

8.Фонограмм бүтээгч нь фонограммыг хуулбарлах, фонограммыг нийтэд түгээх, фонограммын эх хувь болон хуулбарыг түрээслүүлэх, фонограммыг нийтэд дамжуулах, түүнчлэн фонограммыг ашиглуулснаас зохих төлбөр авах эрхийг тусгаж өгнө.

9.Өргөн нэвтрүүлгийн байгууллага нь нэвтрүүлгийн бичлэг хийх, нэвтрүүлгийн бичлэгийг хуулбарлах, нэвтрүүлгийг нэгэн зэрэг дамжуулах, нэвтрүүлгийг түгээх эрхийг тусгаж өгнө.

10.Бүтээлийг зохиогч, зохиогчийн эрх эзэмшигчийн зүй ёсны ашиглалттай зөрчилдөхгүйгээр, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөлгүйгээр бүтээлийг төлбөргүйгээр болон зөвшөөрөлгүйгээр ашиглах тохиолдлууд буюу зохиогчийн эрх болон зохиогчийн эрхэд хамаарах эрхийг хязгаарлах нөхцөлүүдийг нарийвчлан тодорхойлно. Түүнчлэн бүтээлийг төлбөргүйгээр болон зөвшөөрөлгүйгээр ашиглах “шударга ашиглалт”-ын нөхцөлийг хуулийн төсөлд тодорхой заана.

11.Хамтын удирдлагын байгууллагаар дамжуулсан зохиогч болон эрх эзэмшигч бүтээл ашиглах онцгой эрхээ хэрэгжүүлэх үйл явц дэлхий дахинд нэгэнт тогтсон хэлбэр тул хамтын удирдлагын байгууллагын тогтолцоог илүү нарийвчлан тодорхойлох, сайжруулах зөвлөмжийг Зохиогчийн эрхийн хуулийн олон улсын шинжээч зөвлөж байгааг үндэслэн нарийвчлан зохицуулна.

12.Олон улсын нийтлэг жишигт тулгуурлан бүтээл ашиглуулах хэлбэр, нөхцөлийг нарийвчлан тодорхойлно. Тухайлбал, бүтээл ашиглах онцгой эрхийг бүрэн, эсхүл хэсэгчлэн шилжүүлэх байдлаар эрх шилжүүлэх гэрээ, эсхүл бүтээлийг гуравдагч этгээдэд нэгэн зэрэг ашиглуулахгүй байх, эсхүл гуравдагч этгээдэд нэгэн зэрэг

ашиглуулахыг хязгаарлахгүй нөхцөлөөр лицензийн гэрээ байгуулах замаар бүтээлээ ашиглуулж болохоор тусгах. Эрх шилжүүлэх гэрээ болон лицензийн гэрээнд тусгах үндсэн нөхцөлийг нарийвчлан тодорхойлно.

13.Бүтээл ашиглалтын тарифыг хянаж батлах, бүтээл ашиглах, төлбөр төлөх, хуваарилахтай холбоотой гомдлыг урьдчилан шийдвэрлэх, маргаан бүхий талуудыг эвлэрүүлэн зуучлах чиг үүрэг бүхий орон тооны бус Зохиогчийн эрхийн зөвлөлийг байгуулж ажиллуулах эрх зүйн үндэслэлийг бий болгоно.

14.Архив, музей, номын санд хадгалагдаж байгаа бүтээлийг ашиглах онцгой нөхцөлийг тусгана.

15.Хэвлэн нийтлэгдсэн бүтээлийг хараагүй, харааны бэрхшээлтэй, эсхүл хэвлэмэл бүтээл унших бэрхшээлтэй хүмүүст зориулан тэдний хүртэж болох хэлбэрт шилжүүлэн хуулбарлах, хуулбарыг хил дамнуулан солилцох, нийтэд түгээх, нийтийн хүртээл болгоход зохиогчийн эрхийг хязгаарлахтай холбоотой зохицуулалтыг нэмж тусгана.

16.Зохиогч, зохиогчийн эрх өзэмшигч хүсвэл бүтээл болон бүтээл ашиглах онцгой эрхийг шилжүүлэх гэрээ, хэлцлийг оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад сайн дурын үндсэн дээр бүртгүүлэх, бүртгэл хийх журмыг холбогдох эрх бүхий байгууллагаар батлуулах талаар зохицуулалт хийнэ.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар

Зохиогчийн эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсанаар доор дурдсан үр дагавар гарна гэж үзэж байна. Үүнд:

1.Зохиогчийн бүтээлч үйл ажиллагааны илэрхийллийг хамгаалж тэдэнд хуулиар олгогдсон эрхийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлснээр бүтээл туurvигчдыг дэмжин урамшуулах, шинээр бүтээл туurvих боломжийг нэмэгдүүлэх, ингэснээр улс орны эдийг засагт хувь нэмэр оруулах боломжийг нэмэгдүүлэх болно.

2.Зохиогч, уран бүтээлчийн эрхээ хэрэгжүүлэх үндсэн хэлбэр болох хамтын удирдлагын байгууллагын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгосноор зохиогчийн эрхэд хамаарах салбар бүрт “хамтын удирдлагын байгууллага”-ыг шинээр бий болгох боломжийг нэмэгдүүлэх ингэснээр бүтээл туurvигчид хуулиар олгосон эрхээ бүрэн хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлнэ.

3.Цахим болон харилцаа холбооны бусад сүлжээний орчинд зохиогчийн эрхийн хамгаалалтыг тогтолцоог боловсронгуй болгосноор цахим болон харилцаа холбооны бусад сүлжээний орчин дахь зохиогчийн эрхийн зөрчил буурах болно.

4.Зарим нэр томъёоны тодорхойлолтыг тодорхой болгосноор бүтээл туurvигчдын хооронд маргаантай байдаг олон асуудлыг шийдвэрлэх, ойлголтыг нэг мэр болгосноор зохиогчийн эрх бүрэн хангагдах боломжтой болно.

5.Өргөн нэвтрүүлгийн байгууллагын эдлэх эрх, хүлээх үүргийг илүү тодорхой болгосноор нэвтрүүлгийг дамжуулах, нэгэн зэрэг дамжуулахтай холбоотой өргөн нэвтрүүлгийн байгууллага, олон суваг дамжуулагч болон бүтээл туурвигч, эрх эзэмшигчдийн хооронд үүсдэг ойлгоход төвөгтэй асуудлууд зохицуулагдаж, эрхийн хамгаалалт илүү боловсронгуй болох болно.

6.Мэдээллийн сан, компьютерын програмын зохиогчийн эрхийн заалтыг шинээр оруулж өгснөөр мэдээллийн сан, компьютерын програмыг зохиогч болон ашиглагчийн эрх, үүрэг тодорхой болж зохиогчийн эрхийн хамгаалалт сайжрах болно.

7.Кино урлаг буюу дуу авиа бүхий дүрст бүтээлийн зохиогчийн эрхийн хамгаалалтын заалтыг тусад нь зохицуулж өгснөөр кино урлагийн бүтээлийн эрх эзэмшигчийг тодорхой болгож, бүтээл ашиглах онцгой эрхийг эзэмших тал дээр ямар нэгэн маргаан гарахгүй байх боломжийг бий болгоно.

8.Хараагүй, харааны бэрхшээлтэй, эсхүл хэвлэмэл бүтээл унших бэрхшээлтэй хүмүүс хэвлэн нийтлэгдсэн бүтээлийг хүртэх боломжтой болно.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаар

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон Оюуны өмчийн тухай хууль болон бусад хууль тогтоомжтой нийцүүлэх бөгөөд Патентын тухай хууль болон Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуулийн шинэчлэлтэй уялдуулан боловсруулна.

Түүнчлэн хуулийн төсөлтэй холбогдуулан Хууль хүчингүй болсонд тооцох тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Оюуны өмчийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг тус тус боловсруулна.